| | | | |
|---|---|---|---|
| 3.2.7 | Төрийн байгууллагын ёс зүйн зөвлөлийн үйл ажиллагааг идэвхжүүлж, албан хаагчдын ёс зүйн зөрчил, гэмт хэрэг, зөрчилд өртөхөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх ажлыг зохион байгуулах | Монгол улсын Ёс зүйн хорооны 2024 оны 05 дугаар тогтоолоор "Ёс зүйн дэд хорооны ажиллах журам" батлагдсаны дагуу байгууллагын Ёс зүйн дэд хороог 3 хүний бүрэлдэхүүнтэйгээр тус газрын 2024 оны А/47 дугаар тушаалаар шинэчлэн байгуулсан. Байгууллагын ёсзүйн дэд хорооноос 2025 онд 4 зорилтын хүрээнд 12 арга хэмжээг зохион байгуулахаар төлөвлөж, төлөвлөгөөг газрын даргаар батлуулан, хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Байгууллагын ёс зүйн дэд хорооноос танхимын 1 сургалт, төрийн албан хаагч нийгмийг соён гэгээрүүлэгч байх, шударга, ёс зүйтэй харилцаа, хандлагатай холбоотой 8 мэдээллийг дундын мэдээллийн группээр хүргүүлэн зөвлөмж, чиглэлийг өгсөн бол шинээр томилогдсон 3 албан хаагчдад Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль, байгууллагад мөрдөгдөж буй дүрэм, журмыг танилцуулсан. | 100 |
| 3.2.8 | Эрхэлсэн асуудал, хариуцсан ажлынхаа хүрээнд хууль тогтоомж, албан тушаалын тодорхойлолт, чиг үүрэг, ажлын үр дүнг нь гүйцэтгэлийн төлөвлөгөөт ажлын үзүүлэлт, ажлын цаг ашиглалт, бүтээмж, бусдад нөлөөлөх ажил хэргийн болон ёс суртахууны хэмжүүрээр дүгнэж, ажлын хариуцлага, дэг журмыг өндөржүүлэх | Газрын даргын 2025 оны оны А/27 дугаар тушаалаар албан хаагчдын 2025 оны эхний хагас жилийн ажлын гүйцэтгэл, үр дүн, мэргэшлийн түвшинг үнэлэх үнэлгээний багийг байгуулан нэгж болон төрийн албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөөний хагас, бүтэн жилийн тайланг ЗГХЭГДаргын 2023 оны 98 дугаар тушаалаар батлагдсан аргачлалын дагуу үнэлж, үнэлгээний багийн саналыг үндэслэн улирлын ажлын үр дүнгээр маш сайн, хэвийн үнэлэгдсэн албан хаагчдад урамшуулал олгох асуудлыг шийдвэрлэсэн. | 100 |
| 3.2.9 | Төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээг сахиж, ашиг сонирхлын зөрчилгүй ажиллах болон гэмт хэрэг, зөрчилд өртөхөөс урьдчилан сэргийлж, ажлын хариуцлага, сахилга, дэг журмыг бүх шатанд өндөржүүлэн, хууль тогтоомж зөрчсөн, ажлаа цалгардуулсан албан тушаалтанд холбогдох хуулийн дагуу тухай бүр нь хариуцлага тооцох | Монгол Улсын Ёс зүйн хорооны 2024 оны 05 дугаар тогтоолоор "Ёс зүйн дэд хорооны ажиллах журам" батлагдсаны дагуу байгууллагын Ёс зүйн дэд хороог 3 хүний бүрэлдэхүүнтэйгээр тус газрын 2024 оны А/47 дугаар тушаалаар шинэчлэн байгуулсан. Байгууллагын ёс зүйн дэд хорооноос 2025 онд 4 зорилтын хүрээнд 12 арга хэмжээг зохион байгуулахаар төлөвлөж, төлөвлөгөөг газрын даргаар батлуулан, хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Байгууллагын ёс зүйн дэд хорооноос танхимын 1 сургалт, төрийн албан хаагч нийгмийн соён гэгээрүүлэгч байх, шударга, ёс зүйтэй харилцаа, хандлагатай холбоотой 8 мэдээллийг дундын мэдээллийн группээр хүргүүлэн зөвлөмж, чиглэлийг өгсөн бол шинээр томилогдсон 3 албан хаагчдад Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль, байгууллагад | - |

| | | | |
|---|---|---|---|
| | | мөрдөгдөж буй дүрэм, журмыг танилцуулсан. 2025 оны эхний хагас жилийн байдлаар сахилгын шийтгэл оногдуулсан албан хаагч байхгүй. | |
| 3.2.10 | Төрийн гадаад бодлого, үйл ажиллагааны нэгдмэл байдлыг сайжруулах тухай "Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн 2013 оны 01/01 дүгээр зөвлөмж, Засгийн газрын 2013 оны 169 дүгээр тогтоолын хавсралтаар батлагдсан "Төрийн гадаад бодлого, үйл ажиллагааны нэгдмэл байдлыг хангах журам"-ын хэрэгжилтийг хангаж ажиллах | Үндэсний аюулгүй байдлыг хангах арга хэмжээний 2025 оны төлөвлөгөөнд тусгагдсан байгууллагын чиг үүрэгт хамаарах 3 арга хэмжээг хяналтанд авч хэрэгжүүлэн ажилласан. | 100 |
| 3.2.11 | Гадаад улсад албан ёсны эсхүл ажлын айлчлал хийх бол заавал танилцуулж, зөвшөөрөл авах, олон улсын арга хэмжээнд оролцсон, албан ёсны яриа хэлэлцээ явуулсан тухай илтгэх хуудсыг ажлын 7 хоногийн дотор ирүүлж байх | Гадаад улсад албан ёсны эсхүл ажлын айлчлал хийсэн, албан хэргээр зорчсон, олон улсын арга хэмжээнд оролцсон, албан ёсны яриа хэлэлцээ явуулсан тохиолдол байхгүй. | - |
| 3.2.12 | Төрийн байгууллагын баримт бичгийг цахим хэлбэрээр солилцох, "Төрийн байгууллагын дотоод үйл ажиллагааны нэгдсэн ЕКР систем"-ийг бүрэн ашиглаж, мэдээллийг шуурхай солилцох нөхцөлийг сайжруулж, үйл ажиллагаандаа хэвшүүлэх | Байгууллагын дотоод үйл ажиллагаанд (Төрийн байгууллагын дотоод удирдлагын нэгдсэн) "ERP" мөн "ABLE" (Байгууллагын удирдлагын цогц онлайн систем)-ийг бүрэн нэвтрүүлж, 2025 оны хагас жилийн байдлаар 786 албан бичгийг хүлээн авч, 460 албан бичгийг холбогдох байгууллагад хүргүүлэн ажилласан. | 100 |
| 3.2.13 | Мэдээллийн аюулгүй байдлын түвшинг дээшлүүлэх, тоон гарын үсгийн хэрэглээг нэмэгдүүлэх, тоон бичиг үсгийн хэрэглээний мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх, төрийн байгууллагын бүтээмж, үр ашгийг дээшлүүлэх, үйлчилгээний соёлыг хэвшүүлэх | Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын даргын 2025 оны 02 дугаар сарын 18-ны 99 тоот албан бичгээр "Тридум Кей" ХХК-д тоон гарын үсэг олгож өгөх тухай хүсэлтээ явуулж, 03 дугаар сарын 21-ний өдөр тоон гарын үсгийн токен төхөөрөмжөө хүлээн авсан. Төхөөрөмж хүлээн авч төрийн байгууллагуудын албан бичиг солилцооны ERP системд холболт хийж ашиглахад бэлэн болгосон байна. ERP цахим системд тоон гарын үсэг ашиглахад цахим албан бланк хэрэглэдэг ба Архивын ерөнхий газарт 2025 оны албан бланкны загварыг батлуулахаар 2025 оны 03 дугаар сарын 22- | 100 |

| | | | |
|---|---|---|---|
| | | ны өдөр хүсэлтээ өгч уг албан бланкны загвар 04 дүгээр сарын 01-ний өдөр батлагдаж ирсэн байна. Байгууллагын хэмжээнд 1 тоон гарын үсэг ашиглаж байна. | |
| 3.2.14 | Төрийн үйлчилгээний нэгдсэн систем (E-Mongolia)-ээр дамжуулан төрийн үйлчилгээг үзүүлэх, олон нийтийн цахим ур чадвар, чадамжийг дээшлүүлэх талаар сургалт, мэдээллийг хийх, сурталчлах, танилцуулах | Байгууллагын албан ёсны фэйсбүүк хуудсаар дамжуулан шинээр газар эзэмших хүсэлт гаргах, тухайн жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөтэй танилцах, өөрийн эзэмшил газартай холбоотой цахим хүсэлт илгээх, мөн барилга барих зөвшөөрөл авахтай холбоотой 5 инфографик, нийтлэл, зурагт хуудсыг байршуулан олон нийтэд хүргэж, нийт 184 хандалтыг авсан бол газар эзэмших, ашиглахтай холбогдсон үйлчилгээ авсан 137 иргэн, хуулийн этгээдэд зөвлөмж, чиглэлийг өгч ажилласан. | 100 |
| 3.2.15 | Өргөдөл, гомдол, санал, хүсэлт, мэдээллийг цахим сүлжээ болон утсаар хүлээн авах нөхцөл боломжийг бүрдүүлж, дурдсан асуудал, шаардлага бүрийг эрх хэмжээнийхээ хүрээнд нягтлан үзэж, хууль зүйн үндэслэлтэй, бодитой хариуг хуулийн хугацаанд нь өгч эцэслэн шийдвэрлэх | Газар эзэмших, ашиглах болон түүнтэй холбогдон бусад хүсэлтийг цахим системээр хүлээн авч, шийдвэрлүүлэх, баталгаажуулах ажлыг зохион байгуулах ажлын хүрээнд 2025 оны эхний хагас жилийн байдлаар аймгийн хэмжээнд газар эзэмших, ашиглах болон түүнтэй холбогдон нийт 1214 хүсэлтийг хүлээн авснаас 627 хүсэлтийг цахим системээр дамжуулан хүлээн авсан. Цахимаар хүлээн авсан нийт өргөдлөөс 491 хүсэлтийг шийдвэрлэж, 72 хүсэлтийг цуцалсан бол 64 өргөдөл шийдвэрлэгдээгүй байна. | 100 |
| 3.2.16 | Аймгийн Засаг даргын Тамгын газраас зохион байгуулсан сургалт, мэдээллийн цагт удирдах ажилтнууд өөрийн биеэр ирж, ажил хэрэгч оролцох, яригдсан асуудал, удирдлагуудаас өгсөн үүрэг даалгаврыг ажилтан, албан хаагчдад мэдээлж, биелэлтийг хангуулах, ажлын явц, үр дүнг тогтоосон хугацаанд мэдээлж, эргэх холбоотой ажиллах | Аймгийн Засаг даргын Тамгын газраас зохион байгуулсан сургалт, мэдээллийн цагт газрын дарга өөрийн биеэр оролцож, яригдсан асуудал, удирдлагуудаас өгсөн үүрэг даалгаврыг тухай бүр хэрэгжүүлэн ажилласан. | 100 |
| 3.2.17 | Байгууллага хооронд ажлын уялдаа холбоотой ажиллаж, байгууллагын үндсэн чиг үүргийн үзүүлэлт, хяналт-шинжилгээ, үнэлгээний дүнгээр дүгнэгдсэн үнэлгээг өмнөх оноос ахиулж, төрийн үйлчилгээний чанар | Улаанбадрах, Хөвсгөл, Мандах, Эрдэнэ, Алтанширээ, Иххэт сум, Сайншанд сумын Зүүнбаян багт 2025 оны 1, 2 дугаар сард зохион байгуулагдсан арга хэмжээний үеэр газартай холбоотой төрийн үйлчилгээний чиглэлээр хэрэгжүүлбэл зохих, тулгамдаж буй асуудлын талаарх судалгааг авсан. Судалгааны үр дүнг үндэслэн тус газраас төрийн | 100 |

| | | | |
|---|---|---|---|
| | хүртээмжийг дээшлүүлэх | байгууллага хоорондын уялдаа холбоо, хамтын ажиллагааг сайжруулах, иргэн хуулийн этгээдэд төрийн үйлчилгээг хүндрэл чирэгдэлгүй үзүүлэх, нэгдсэн ойлголтод хүрэх хамтарсан уулзалтыг аймгийн Улсын бүртгэлийн хэлтэстэй 2025 оны 05 сард зохион байгуулж, үл хөдлөх эд хөрөнгөд гэрчилгээ олгох, Гадаадын хөрөнгө оруулалттай хуулийн этгээдийн шилжилт хөдөлгөөн, Хаягийн асуудал зэргээр харилцан санал солилцож, төрөөс үзүүлж буй үйлчилгээнд гарч буй хүндрэл чирэгдэлтэй холбоотой асуудалд нэгдсэн ойлголтод хүрч, төрийн үйлчилгээг нэг дороос үзүүлэх арга хэмжээг цаашид бүсчилсэн хэлбэрээр тогтмол хамтран зохион байгуулж, хамтран ажиллах санамж бичгийг байгуулсан. | |
| 3.2.18 | Хуулиар хүлээсэн үндсэн чиг үүрэг, аймгийн удирдлагаас өгсөн үүрэг, даалгаврын биелэлт, шинээр санаачлан хэрэгжүүлсэн ажлын гүйцэтгэлийн явцыг танилцуулж ажиллах, тухайн ажлын гүйцэтгэлтэй уялдуулан орон нутгийн нэмэгдэл олгох эсэх асуудлыг шийдвэрлэх | Аймгийн Засаг дарга, түүний орлогч, Засаг даргын Тамгын газрын дарга зэрэг удирдлагаас өгсөн үүргийг цаг хугацаанд нь чанартай, үр дүнтэй, шуурхай хэрэгжүүлж ажилласан. | 100 |
| 3.2.19 | Улс, бүсийн сургалт, зөвлөгөөнд хамрагдан шинэ мэдлэг, мэдээллээ үйл ажиллагаандаа хэрхэн нэвтрүүлсэн болон шинээр санаачлан хэрэгжүүлсэн ажлын гүйцэтгэл, үр дүнг тухай бүр танилцуулж байх | ГЗБГЗЗГазар, БХТөвөөс Улаанбаатар хотод 2025 оны 01-р сарын 30-31-ний өдрүүдэд зохион байгуулсан салбарын удирдах ажилтны зөвлөгөөнд газрын даргын түр орлон гүйцэтгэгч Л.Олзбаяр, газрын удирдлагын хэлтсийн дарга Н.Оюунгэрэл, Ц.Баярмаа нар тус тус хамрагдсан. | 100 |
| 3.2.20 | Аймгийн Засаг даргын захирамжаар байгуулагдсан ажлын хэсгийн үйл ажиллагаанд идэвх санаачилгатай, үр дүнтэй биечлэн оролцох | 2025 онд аймгийн Засаг даргын захирамжаар байгуулагдсан 7 ажлын хэсэг 4 албан хаагч орж ажилласан. | 100 |
| 3.2.21 | Албаны болон хувийн ажлаар дотоод, гадаадад явахдаа аймгийн Засаг даргад заавал мэдэгдэн, удирдамж, хөтөлбөр | Албаны болон хувийн ажлаар явахдаа тухай бүр аймгийн Засаг даргад мэдэгдэн, удирдамж, хөтөлбөрөө батлуулан, зөвшөөрөл авч ажилласан. | 100 |

| | | | |
|---|---|---|---|
| | батлуулан, зөвшөөрөл авах | | |
| 3.2.22 | Аймгийн Засаг дарга, орлогч, Засаг даргын Тамгын газрын дарга зэрэг удирдлагаас өгсөн үүргийг цаг хугацаанд нь чанартай, үр дүнтэй, шуурхай хэрэгжүүлж, үр дүнг тухай бүр танилцуулах | Аймгийн Засаг дарга,түүний орлогч, Засаг даргын Тамгын газрын дарга зэрэг удирдлагаас өгсөн үүргийг цаг хугацаанд нь чанартай, үр дүнтэй, шуурхай хэрэгжүүлж ажилласан. | 100 |

АЙМГИЙН ГАЗРЫН ХАРИЛЦАА, БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН ГАЗАР

**Эх сурвалжийн дэлгэрэнгүй мэдээлэл**
**Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын дарга Л.Олзбаяр**
**Цахим шуудан: Olzbayar.o@dornogovi.gazar.gov.mn**
**Холбоо барих утас: 86038393**

**Эх сурвалжийн дэлгэрэнгүй мэдээлэл**
**Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын Захиргаа,**
**хуулийн асуудал хариуцсан ахлах мэргэжилтэн Б.Батбаатар**
**Цахим шуудан: batbaatar.b@dornogovi.gazar.gov.mn**
**Холбоо барих утас: 90828240**